



ХӨСӨГ ТРЕЙД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТОГТООЛ

2024 оны 04 сарын 01 өдөр

дугаар 05

Улаанбаатар хот

Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын компанийн тухайн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.32.16 дахь заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Милко” ХХК-ийн “Хаан Банк”-наас авч буй хөрөнгө оруулалтын зориулалттай 25.0 тэрбум төгрөгийн 60 сарын хугацаатай, жилийн 16.8 хувийн хүүтэй, зээлийн үндсэн төлбөрөөс эхний 12 сар чөлөөлөх нөхцөлтэй зээлийн барьцаанд “Хөсөг Трейд” ХК-ийн улсын бүртгэлийн Э-2205002334, нэгж талбарын 1681600482 дугаартай газар болон улсын бүртгэлийн Ү-2205011243 дугаартай үл хөдлөх хөрөнгийг барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан газар болон үл хөдлөх хөрөнгө барьцаалах хэлцэл нь их хэмжээний хэлцэл болохыг дурдсугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу барьцааны гэрээ болон бусад холбогдох бүхий л баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /М.Эрдэнэсүх/-д олгосугай.
4. Милко ХХК-ийн 25.0 тэрбум төгрөгийн зээлийн барьцаанд тавих Хөсөг трейд ХК-ийн газар болон үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг энэхүү тогтоолын хавсралт №1-д зааснаар тогтоож барьцаалахыг зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



С.БОЛОР


ГИШҮҮД:

Ж.ГАНТОГТОХ


Г.МАРГАД

С.БАТ-ӨЛЗИЙ

 С.ЖАВЗАН-ОРЛОМ

 Д.БАДАМ

 Ц.ДАМЖИН

 Т.ӨЛЗИЙБҮРЭН

 Р.ГАНСҮХ



ХӨСӨГ ТРЕЙД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТОГТООЛ

2024 оны 04 сарын 01 өдөр

дугаар 06

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 7.32.17 дэх заалт болон болон 2024 оны 04 сарын 01-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Милко” ХХК-ийн “Хаан Банк”-наас авч буй хөрөнгө оруулалтын зориулалттай 25.0 тэрбум төгрөгийн 60 сарын хугацаатай, жилийн 16.8 хувийн хүүтэй, зээлийн үндсэн төлбөрөөс эхний 12 сар чөлөөлөх нөхцөлтэй зээлийн барьцаанд “Хөсөг Трейд” ХК-ийн улсын бүртгэлийн Э-2205002334, нэгж талбарын 1681600482 дугаартай газар болон улсын бүртгэлийн Y-2205011243 дугаартай үл хөдлөх хөрөнгийг барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэл тул ТУЗ-ийн гишүүн Д.Бадам, С.Жавзан-Орлом, С.Бат-Өлзий, С.Болор, Ж.Гантогтох, Г.Маргад нарын хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэл болохын хувьд эдгээр гишүүдээс бусад бүх гишүүд санал нэгтэй зөвшөөрсөн болохыг тэмдэглэсүгэй.
3. Энэхүү тогтоолын 1-д заасны дагуу барьцааны гэрээ болон бусад холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх Захирал /М.Эрдэнэсүх/-д олгосугай.
4. “Милко” ХХК-ийн 25 тэрбум төгрөгийн зээлийн барьцаанд тавих Хөсөг трейд ХК-ийн газар болон үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг энэхүү тогтоолын хавсралт №1-т зааснаар тогтоож барьцаалахыг зөвшөөрсүгэй.

ГИШҮҮД



Ц.ДАМЖИН

Т.ӨЛЗИЙБҮРЭН

Р.ГАНСҮХ